

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.08.13 № 01/64
танай _____-ны № _____-т

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БЯМБАЖАВ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 62,143.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 42,044.4 мянган төгрөгийн техник хэрэгсэл, ОНХС-ийн хөрөнгөөр 246,538.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, ойн хандиваас 17,788.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 113,194.9 мянган төгрөгийн техник хэрэгсэл зэрэг хөрөнгүүдийг хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсвөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авсан болон гар утасны зардалд нийт 730.0 мянган төгрөгийг зарцуулж үр ашиггүй зардал гаргасан, өмнөх оны авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргын Тамгын газрын дарга нь сумын Засаг даргатай 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 92.7 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,851,450.80	118,420,348.80
33	АВЛАГА	19,134,001.00	13,282,796.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,134,001.00	13,282,796.00
35	БАРАА МАТЕРИАЛ	100,717,449.80	105,137,552.80
351	Түүхий эд материал	2,864,352.00	00.00
35130	Эм боох материал	2,864,352.00	00.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,000,000.00	2,000,000.00
354	Хангамжийн материал	94,473,097.80	103,137,552.80
35410	Бичиг хэргийн материал	7,292,275.00	2,813,875.00
35420	Аж ахуйн материал	8,315,770.00	1,896,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,009,500.00	140,000.00
35470	Бусад хангамжийн материал	74,855,552.80	98,287,677.80
35600	Мал амьтад	1,380,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,169,023,110.68	2,677,017,615.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,169,023,110.68	2,677,017,615.10
392	Биет хөрөнгө	2,152,770,110.68	2,048,211,615.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,852,047,797.00	1,658,940,575.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-285,292,535.91	-329,564,623.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	188,332,396.00	299,884,831.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,721,451.44	-85,771,985.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,054,820.00	183,318,784.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,021,571.06	-59,229,352.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,118,096.00	52,518,096.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,100,710.36	-20,035,402.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	363,998,500.00	379,098,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-22,645,229.55	-30,947,805.99
393	Биет бус хөрөнгө	16,253,000.00	628,806,000.04
39301	Програм хангамж	1,985,000.00	1,985,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-575,000.00	-971,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	14,843,000.00	627,793,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,288,874,561.48	2,795,437,963.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,288,874,561.48	2,795,437,963.90
51	Засгийн газрын хувь оролцоо	2,288,874,561.48	2,795,437,963.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	492,113,245.39	1,105,063,245.39
51101	Өмч: - төрийн	492,113,245.39	1,105,063,245.39
512	Хуримтлагдсан үр дүн	1,559,404,467.09	1,453,017,869.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1,559,404,467.09	1,559,404,467.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-106,386,597.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	237,356,849.00	237,356,849.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,288,874,561.48	2,795,437,963.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	756,594,481.00	1,108,646,677.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,544,300.00	391,124,877.00
120	Нийтлэг татварын бус орлого	191,544,300.00	391,124,877.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	565,050,181.00	717,521,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,229,481.00	17,644,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,855,000.00	3,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,474,949.00	4,172,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,899,532.00	10,372,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	517,820,700.00	699,877,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	517,820,700.00	699,877,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	685,731,809.48	772,798,426.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	685,731,809.48	772,798,426.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,568,287.48	676,052,361.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,933,531.00	266,804,471.00
210101	Үндсэн цалин	250,438,919.00	212,571,955.00
210102	Нэмэгдэл	6,494,612.00	36,753,164.00
210104	Урамшуулал	00.00	17,479,352.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,172,731.00	34,411,827.83
210201	Тэтгэврийн даатгал	23,934,075.97	23,669,576.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,569,135.52	2,781,444.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,055,308.41	2,161,315.94
210204	Ажилгүйдлийн даатгал	510,381.92	527,226.26
210205	Эрүүл мэндийн даатгал	5,103,829.18	5,272,264.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,131,579.00	66,479,068.43
210301	Гэрэл, цахилгаан	5,491,752.00	4,767,537.43
210302	Түлш, халаалт	59,639,827.00	61,711,531.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,516,155.00	78,412,255.00
210401	Бичиг хэрэг	2,985,870.00	7,018,950.00
210402	Тээвэр, шатахуун	20,079,600.00	41,885,065.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,529,585.00	2,883,800.00
210404	Ном, хэвлэл	374,600.00	70,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,000.00	10,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,461,500.00	13,025,190.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	13,518,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,315,000.00	23,130,005.00
210604	Урсгал засвар	1,315,000.00	23,130,005.00
2107	Томиллолт, зочны зардал	1,600,000.00	2,965,800.00
210702	Дотоод албан томиллолт	1,600,000.00	2,965,800.00

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,587,593.00	8,558,803.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,541,819.00	6,907,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	65,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,974.00	212,003.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,800.00	53,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	700,000.00
210807	Газрын төлбөр	2,300,000.00	620,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,311,698.48	195,290,131.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,013,622.00	38,517,807.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,910,500.00	1,392,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	127,387,576.48	155,379,824.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,163,522.00	96,746,064.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,120,500.00	41,200,160.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	32,575,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,620,500.00	8,625,160.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	90,043,022.00	55,545,904.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,043,022.00	55,545,904.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	70,862,671.52	335,848,250.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,695,833.25	442,234,848.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	28,695,833.25	431,284,848.48
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,000,000.00	10,950,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-29,695,833.25	-442,234,848.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,166,838.27	-106,386,597.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			<i>Төгрөгөөр/</i>
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	565,050,181.00	723,373,005.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	565,050,181.00	723,373,005.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,229,481.00	23,495,205.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,855,000.00	3,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,474,949.00	4,172,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,899,532.00	16,223,205.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	517,820,700.00	699,877,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	517,820,700.00	699,877,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	559,230,281.00	599,228,105.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	559,230,281.00	599,228,105.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,066,759.00	502,482,040.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,246,401.00	266,804,471.00
210101	Үндсэн цалин	228,994,301.00	212,571,955.00
210102	Нэмэгдэл	30,252,100.00	36,753,164.00
210104	Урамшуулал	00.00	17,479,352.00

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,334,579.00	34,411,827.83
210201	Тэтгэврийн даатгал	25,124,917.00	23,703,751.31
210202	Тэтгэмжийн даатгал	2,562,786.00	2,772,900.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,049,150.00	2,154,480.92
210204	Ажилгүйдлийн даатгал	508,394.00	525,517.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,089,332.00	5,255,177.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,131,579.00	66,479,068.43
210301	Гэрэл, цахилгаан	5,491,752.00	4,767,537.43
210302	Түлш, халаалт	59,639,827.00	61,711,531.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,878,985.00	58,881,565.00
210401	Бичиг хэрэг	3,835,500.00	3,415,900.00
210402	Тээвэр, шатахуун	20,079,600.00	41,776,565.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,529,585.00	2,883,800.00
210404	Ном, хэвлэл	374,600.00	310,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	85,000.00	10,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,974,700.00	10,485,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,257,000.00	23,459,000.00
210604	Урсгал засвар	4,257,000.00	23,459,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,600,000.00	2,965,800.00
210702	Дотоод албан томилолт	1,600,000.00	2,965,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,551,643.00	10,568,803.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,505,869.00	8,917,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	65,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,974.00	212,003.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,800.00	53,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	700,000.00
210807	Газрын төлбөр	2,300,000.00	620,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,066,572.00	38,911,505.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,156,072.00	37,519,005.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,910,500.00	1,392,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,163,522.00	96,746,064.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,120,500.00	41,200,160.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	32,575,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,620,500.00	8,625,160.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	90,043,022.00	55,545,904.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	90,043,022.00	55,545,904.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,819,900.00</u>	<u>124,144,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,819,900.00	124,144,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,819,900.00	124,144,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,819,900.00	124,144,900.00
223001	Бусад хөрөнгө	00.00	10,950,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,819,900.00	113,194,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,819,900.00</u>	<u>-124,144,900.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Легрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,113,245.39	237,929,435.61	1,499,941,024.94	00.00	2,229,983,705.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	492,113,245.39	237,929,435.61	1,499,941,024.94	00.00	2,229,983,705.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,932,492.61	00.00	28,932,492.61
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,113,245.39	237,356,849.00	1,559,404,467.09	00.00	2,288,874,561.48
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,113,245.39	237,356,849.00	1,559,404,467.09	00.00	2,288,874,561.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	492,113,245.39	237,356,849.00	1,559,404,467.09	00.00	2,288,874,561.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	612,950,000.00	00.00	00.00	00.00	612,950,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-106,386,597.58	00.00	-106,386,597.58
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,063,245.39	237,356,849.00	1,453,017,869.51	00.00	2,795,437,963.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	600,927,800.00	545,381,895.26	55,545,904.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600,927,800.00	545,381,895.26	55,545,904.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,668,500.00	504,181,735.26	54,486,764.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,725,600.00	264,704,471.00	26,021,129.00
210101	Үндсэн цалин	229,391,900.00	212,571,955.00	16,819,945.00
210102	Нэмэгдэл	45,067,800.00	36,753,164.00	8,314,636.00
210104	Урамшуулал	16,265,900.00	15,379,352.00	886,548.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,888,600.00	34,411,827.83	3,476,772.17
210201	Тэтгэврийн даатгал	26,259,400.00	23,703,751.31	2,555,648.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,907,400.00	2,772,900.94	134,499.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,325,700.00	2,154,480.92	171,219.08
210204	Ажилгүйдлийн даатгал	581,600.00	525,517.51	56,082.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5,814,500.00	5,255,177.15	559,322.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,000,000.00	66,479,068.43	5,520,931.57
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	4,767,537.43	2,232,462.57
210302	Түлш, халаалт	64,750,000.00	61,711,531.00	3,038,469.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	00.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,000,000.00	53,334,565.00	4,665,435.00
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,415,900.00	584,100.00
210402	Тээвэр, шатахуун	42,500,000.00	39,244,565.00	3,255,435.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,853,800.00	146,200.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	310,300.00	89,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	10,000.00	590,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,500,000.00	7,500,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,795,000.00	42,794,900.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,720,000.00	22,719,900.00	100.00
210604	Урсгал засвар	20,075,000.00	20,075,000.00	0.00
2107	Томиллолт, зочны зардал	3,000,000.00	2,965,800.00	34,200.00
210702	Дотоод албан томиллолт	3,000,000.00	2,965,800.00	34,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,073,400.00	13,043,803.00	2,029,597.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,129,700.00	11,392,650.00	1,737,050.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	65,450.00	4,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	212,003.00	287,997.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	53,000.00	53,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	700,000.00	0.00
210807	Газрын төлбөр	620,700.00	620,700.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39185900.00	26447300.00	12,738,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,185,900.00	25,054,800.00	10,131,100.00

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	1,392,500.00	2,607,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42259300.00	41200160.00	1,059,140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,259,300.00	41,200,160.00	1,059,140.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,575,000.00	32,575,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,684,300.00	8,625,160.00	1,059,140.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,950,000.00	98,950,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	98,950,000.00	98,950,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	98,950,000.00	98,950,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	699,877,800.00	644,331,895.26	55,545,904.74
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	699,877,800.00	644,331,895.26	55,545,904.74
132001	Орон нутгийн төсвөөс	699,877,800.00	644,331,895.26	55,545,904.74
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	24.00	1.00
620001	Удирдах ажилтан	10.00	09.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		23,495,205.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		23,495,205.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		23,495,205.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,100,000.00
210104	Урамшуулал		2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5,547,000.00
210402	Тээвэр, шатахуун		2,532,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,985,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,384,000.00
210604	Урсгал засвар		3,384,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		12,464,205.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		12,464,205.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		23,495,205.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		23,495,205.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		3,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,172,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		16,223,205.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тус байгууллага нь албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг ханган төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж орон нутагтаа сайн сайхан, эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэн үйл ажиллагаагаараа үргэлж манлайлсан аймгийн тэргүүний Тамгын газар байхад оршино гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй, ил тод хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгох.

ЗДТГ-ын дарга нь Цэцэрлэг сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 92.7 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу ЗДТГ-ын даргын 2022 оны 05 сарын 31 өдрийн А/22 тоот тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан цаг ашиглалт, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу тамгын газрын дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 329,688.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	19,134.0	13,282.8	5,851.2
Бараа материал	100,717.4	105,137.5	4,420.1
Үндсэн хөрөнгө	2,169,023.1	2,677,017.6	273,170.1
Нийт хөрөнгө	2,288,874.5	2,795,437.9	329,688.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	492,113.2	1,105,063.2	612,950.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,288,874.5	2,795,437.9	329,688.7

/мянган төгрөгөөр/

Дээрх хүснэгтээс харахад авлага буурч, бараа материал, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн, мөн Засгийн газрын хувь оролцоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэсэн өвсний үнийн авлагыг багийн дарга нараас суутган авснаар авлагын үлдэгдэл буурсан байна.
2. Бараа материалын дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь үнэ төлбөргүй орлого болох ойн хандив болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой. ОНХС-аар 20,231.0 мянган төгрөгийн өртөгтэй бараа материал, ойн хандиваас 2,346.6 мянган төгрөгийн өртөгтэй бараа материал бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн 13,518.9 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 62,143.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 42,044.4 мянган төгрөгийн техник хэрэгсэл, ОНХС-ийн хөрөнгөөр 246,538.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, ойн хандиваас 17,788.0 мянган төгрөгийн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр 113,194.9 мянган төгрөгийн техник хэрэгсэл зэрэг хөрөнгүүд нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн 462,000.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 13,500.0 төгрөгийн хөрөнгө акталсан байна.
4. Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ нэмэгдсэн шалтгаан нь 612,950.0 мянган төгрөгийн 24 газрыг бүртгэлд авч тайланд тусгасан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 580,487.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал дээр 119,390.6 мянган төгрөгийн төсвийг нэмж баталсан байна. Энэ нь тогтмол зардлын өртөг, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал, орон нутгийн нөөцийн зардал, улсын баяр наадмын зардлыг нэмэгдүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 48,197.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 699,877.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 516,952.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, дансны үлдэгдлээс 182,924.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 644,331.9 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 53,808.9 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 1,737.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	587,798.1	533,989.2	53,808.9	90.8
2	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх	13,129.7	11,392.7	1,737.0	86.8
3	Хөрөнгө оруулалт	98,950.0	98,950.0	-	100.0
	Дүн	699,877.8	644,331.9	55,545.9	92.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 3,872.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хамтарсан багийн дэмжлэгт 300.0 мянган төгрөг олгосон бөгөөд цахим тендерийн бичиг баримтын үнэ 490.0 мянган төгрөг, Могойн гол ХХК-аас 3,100.0 төгрөгийн ковидын хандив, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас 16,223.2 төгрөг нийт 23,495.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Хагас жилийн мал тооллогын урамшуулал, шуудан холбооны зардалд 2,130.0 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 12,464.2 мянган төгрөг, тээвэр шатахуунд 2,532.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 2,985.0 төгрөг, урсгал засварын зардалд 3,384.0 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 13,714.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,971.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн.

Горим сорилыг хэрэгжүүлэх явцад байгууллагын төсвөөс 230.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, гар утасны зардалд 500.0 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цэцэрлэг сумын Хүн эмнэлгийн хэрэгцээнд гэж ЗДТГ-ын хөрөнгийн зардалд 88,000.0 мянган төгрөгийг тусган батлуулж 88,000.0 мянган төгрөгөөр toyota land cruiser prado-150 маркийн авто машиныг худалдан авсан байна. Тус сумын хүн эмнэлэгт авто машиныг сумын ИТХ-ын тогтоолоор

шилжүүлсэн боловч авто машиныг ЗДТГ эзэмшиж ашиглаж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нийт 106,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд авлага барагдуулах, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга бэлтгэж байх, хандив тусламжийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах, хөрөнгийг урсгал зардалд зарцуулахгүй байх, байгууллагынхаа төсөвт бусад байгууллагын хэрэгцээнд гэж хөрөнгө оруулалтын зардал батлуулахгүй байх нийт 5 зөвлөмжийг хүргүүлсэн.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар хэрэгжилтийг дахин тооцож ажиллаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 107,500.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	107,500.0	4	107,500.0	100
Нийт дүн	4	107,500.0	4	107,500.0	100

Өмнөх онд акт, албан шаардлага өгөөгүй бөгөөд 107,500.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 102,012.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 730.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 101,282.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

- Байгууллагын төсвөөс 230.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.
- Эгшиглэнт-Үйлс ХХК-д 500.0 мянган төгрөгийг шилжүүлж 2000 төгрөгийн хоноггүй 250 нэгжийн карт худалдан авч зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд 730.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын дансанд хувь хүмүүсээс авах 13.282.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Уг авлага нь буруутай шийдвэр гаргаж албан хаагчийг ажлаас нь чөлөөлсөнтэй холбоотой бөгөөд одоог хүртэл авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

2. Хөрөнгийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэцэрлэг сумын Хүн эмнэлгийн хэрэгцээнд гэж ЗДТГ-ын хөрөнгийн зардалд 88,000.0 мянган төгрөгийг тусган батлуулж 88,000.0 мянган төгрөгөөр toyota land cruiser prado-150 маркийн авто машиныг худалдан авсан байна. Тус сумын хүн эмнэлэгт авто машиныг сумын ИТХ-ын тогтоолоор шилжүүлсэн боловч авто машиныг ЗДТГ ашиглаж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	3	14,012.8	1	730.0			1	13,282.8				
Дүн	3	14,012.8	1	730.0			1	13,282.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хөрөнгийн эзэмшил, ашиглалттай холбоотой	1	88,000.0					1	88,000.0
Дүн	1	88,000.0					1	88,000.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО: